

2017 ОНЫ II УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР



Улаанбаатар хот
2017 он

АГУУЛГА

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА.....	2
1.1 Өргөдөл, гомдлын утга, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл	2
1.2 Салбарын үзүүлэлтүүд	3
1.2.1 Үнэт цаасны зах зээл	4
1.2.2 Даатгалын салбар.....	5
1.2.3 Банк бус санхүүгийн байгууллага.....	6
1.2.4 Хадгаламж зээлийн хоршоо	6
2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ	7
3. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ.....	7

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Хороонд ирүүлсэн өргөдөл гомдлын утга.....	2
Хүснэгт 2. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл	3
Хүснэгт 3. Даатгалын салбарын өргөдлийн төрөл	5
Хүснэгт 4. ББСБ болон бусад асуудлаар ирүүлсэн өргөдөл	6
Хүснэгт 5. ХЗХ-той холбоотой ирүүлсэн өргөдөл.....	6
Хүснэгт 6. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал	7

ДҮРСЛЭЛ


Дүрслэл 1. СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо (улирлаар)	2
Дүрслэл 2. Өргөдөл, гомдлын тоо (салбараар)	4
Дүрслэл 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл.....	4
Дүрслэл 4. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)	7

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, гомдлыг барагдуулах талаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2016 оноос өнөөг хүртэл Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын улирлын судалгааг дор үзүүлэв:

Дурслал 1. СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо (улирлаар)



1.1 Өргөдөл, гомдлын утга, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл

2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тус Хороо санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар нийт 135 өргөдөл, гомдлыг хүлээн авсан бол 2017 оны 2 дугаар улирал буюу 4-6 сард нийт 49 өргөдөл ирсэн байна. Өргөдөл, гомдлын харьцуулсан судалгааг утгаар нь¹ ангилж, хүснэгтлэн харуулав:

Хүснэгт 1. Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын утга

Д/д	Өргөдөл, гомдлын утга	2017/І	2017/ІІ	Өссөн дүнгээр
1	Зээлийн гэрээний маргаан*	9	7	16
2	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа	3	2	5
3	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа	2	1	3
4	Хувьцааны өмчлөл	16	7	23
5	Хувьцаат компанийн үйл ажиллагаа	2	1	3
6	Үнэт цаасны бүртгэл	5	4	9
7	Даатгалын нөхөн төлбөр	40	21	61
8	Даатгалын компанийн үйл ажиллагаа	1	1	2
9	Даатгалын хохирлын үнэлгээ	1	1	2
10	Зээлийн мэдээллийн сан	2	2	4
11	Бусад (ломбард, иргэд хоорондын гэрээний маргаан, гэрлэлтийн даатгал, сүлжээний бизнес гэх мэт)	5	2	7

¹Санхүүгийн хэрэглэгчийн зүгээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг утгаар нь багцлав.

*Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршооны зээлийн маргааныг хамтад нь оруулав.

- *Харьцуулалтаар, Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцааны арилжаатай холбоотойгоор 2017 оны 2 дугаар улиралд Хороонд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтийг мөн оны 1 дүгээр улиралтай харьцуулахад хамгийн их буюу 56.0 хувиар буурав.*
- *Тайлант улиралд ирсэн нийт өргөдөл, гомдлын тоо өмнөх улирлаас 44.1 хувиар буурч, 2016 оны 2 дугаар улирлын нөхцөл байдалтай ижил давтамж ажиглагдлаа.*

Тайлант хугацаанд Хороонд ирсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр² бүлэглэн дор харуулав.

Хүснэгт 2. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийн төрөл

Д/д	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	2017/І	2017/ІІ
1	Зээлийн гэрээний маргаан	5	4
2	Зээлийн хүүгийн маргаан	4	3
3	Банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээ	3	2
4	Хадгаламж, зээлийн хоршооны үйлчилгээ	2	1
5	Өмчлөгчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаа	16	7
6	Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг	4	3
7	Хувьцаат компанийн ногдол ашиг	2	1
8	Үнэт цаасны бүртгэл	1	1
9	Жолоочийн хариуцлагын даатгал	14	9
10	Тээврийн хэрэгслийн даатгал	13	5
11	Орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгал	10	4
12	Бусад даатгал	3	3
13	Даатгалын компанийн үйлчилгээ	1	1
14	Даатгалын хохирлын үнэлгээ	1	1
15	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	2	2
16	Бусад (ломбард, иргэд хоорондын гэрээний маргаан, гэрлэлтийн даатгал, сүлжээний бизнес гэх мэт)	5	2

- *Зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаа, тээврийн хэрэгслийн болон орон сууц зээлдэгчийн эрсдэлийн даатгалын нөхөн төлбөрийн маргаантай холбоотой өргөдөл, гомдлын тоо өмнөх улиралтай харьцуулахад хамгийн өндөр хувиар буурав.*
- *Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн нийт өргөдлийн 57.7 хувийг өмчлөгчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаа, жолоочийн хариуцлагын, тээврийн хэрэгслийн болон орон сууц зээлдэгчийн эрсдэлийн даатгалын маргаан зэрэг 4 асуудалтай холбоотой гомдлууд илэрхийлж байна.*


1.2 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д заасны дагуу чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2017 оны 2 дугаар улиралд (өссөн дүнгээр) ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

²Санхүүгийн хэрэглэгчийн зүгээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдолд бүтээгдэхүүн, үйлчилгээг төрлөөр нь багцлав.

Тайлант хугацаанд нийт 135 өргөдөл, гомдол ирснийг салбараар нь ангилбал:

Дүрслэл 2. Өргөдөл, гомдлын тоо (салбараар)



Дүгнэхэд, 2017 оны 2 дугаар улиралд ирсэн өргөдөл, гомдлын тоог өмнөх улиралтай харьцуулахад, үнэт цаасны зах зээлийн болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой гомдол 50, хадгаламж, зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагын хувьд 30 орчим хувиар буурсан, харин бусад асуудлаар Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо нэмэгджээ.

1.2.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 35 өргөдөл, гомдол ирснээс хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэсэн 32, үлдэх 3 нь хянагдах шатанд байна.

Өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилбал:

Дүрслэл 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл



Үнэт цаасны салбарт ирж буй нийт өргөдлийн 65.0 хувь нь эзэмшигчийн зөвшөөрөлгүй хийгдсэн арилжаа эзэлж байгаа бөгөөд үүнээс 40.0 гаруй хувийг өмнө нь Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 17 брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалсан байна.

Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэн нийт 418,993.0 төгрөгийн хохирлыг барагдуулан “Улаанбаатар БҮК” ХК-ийн 150, “Ариг гал” ХК-ийн 168 ширхэг хувьцааг хууль ёсны эзэмшигчийн дансуудад тус тус нөхөн байршуулав.

1.2.2 Даатгалын салбар

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 65 өргөдөл Хороонд ирснээс 62 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн бөгөөд 3 гомдол хянагдах шатанд байна.

Хүснэгт 3. Даатгалын салбарын өргөдлийн төрөл

№	Даатгалын төрөл	Өргөдлийн тоо
1	Жолоочийн хариуцлагын даатгал	23
2	Тээврийн хэрэгслийн даатгал	18
3	Орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгал	14
4	Бусад даатгал	6
5	Даатгалын компанийн үйлчилгээ	2
6	Даатгалын хохирлын үнэлгээ	2

Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлүүдээр ангилбал, жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн болон орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгалын тохиолдлууд нийт гомдлын 84.6 хувийг эзэллээ.

- *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 23 тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсан 18, даатгалын хохирол үнэлгээтэй холбоотой 1, нөхөн төлбөрийг дутуу олгосон 4 маргаан байв.*
- *Тээврийн хэрэгслийн даатгалын 18 тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсаны хамгийн их буюу 6 нь даатгуулагч даатгалын гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу Замын цагдаагийн газар, даатгагчид мэдэгдээгүй, хохирлын хэмжээг тодорхойлоогүй, даатгалын зүйлийг засварласан, мөн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлтэй 4, даатгалын гэрээнд заасан эрсдэлээс өөр төрлийн эрсдэл учирсан 3, үлдсэн нь бусад шалтгаанаар нөхөн төлбөр олгохоос татгалзсан байв.*
- *Орон сууцны зээлдэгчийн гэнэтийн ослын 14 даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзсан хамгийн давтагдсан тохиолдол нь хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан үед даатгалын нөхөн төлбөрийг нэг жилд хамааруулан үндэслэлгүйгээр хасч олгосон 6, даатгуулсан хохирлын дүнг үндэслэлгүй бууруулж олгосон 4, үлдсэн нь бусад шалтгаанаар нөхөн төлбөр олгохоос татгалзсан байлаа.*

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, нийт 66,553,473.0 (Жаран зургаан сая таван зуун тавин гурван мянга дөрвөн зуун далан гурван) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг олгуулсан байна. Дүгнэвэл, даатгалын компани нөхөн төлбөр олгохоос татгалзсан тоо буурч байгаа бөгөөд татгалзсан тохиолдлын ихэнх нь эрх зүйн үндэслэлтэй байв.

1.2.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 16, бусад (ломбард, иргэд хооронд байгуулсан зээлийн гэрээ) 7 өргөдөл, гомдлыг тус тус Хороонд ирүүлснээс 22 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт 4. ББСБ болон бусад асуудлаар ирүүлсэн өргөдөл

Д/д	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл	2017/П
1	Зээлийн гэрээний маргаан	5
2	ББСБ-ын үйлчилгээ	5
3	Үндсэн болон нэмэгдүүлсэн хүүгийн маргаан	4
4	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	2
5	Бусад /ломбард, иргэд хоорондын гэрээ/	7

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнхийг зээлийн хүү, алданги буруу тооцсон, барьцаа хөрөнгийг буцаан олгоогүй, эсхүл барьцаанаас чөлөөлөөгүй, зээлдэгчийн эрх зүй болон санхүүгийн мэдлэг дутмаг байгааг ашиглан зээлийн гэрээг тухайн ББСБ өөртөө давуу эрх олгох байдлаар байгуулсан, хувь хүний мэдээллийг бусдад задруулсан зэрэг гомдол эзэлжээ.

Мөн зээлээ бүрэн барагдуулсан зээлдэгчдийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлэн бүртгээгүйн улмаас хувь хүний зээлийн ангилалд сөргөөр нөлөөлсөн, зээлийн хүүгийн хэмжээ харилцан адилгүй болон зээлийн хүүг урьдчилан авдаг асуудлыг зохицуулах зорилгоор нэр бүхий 8 ББСБ-д газар дээрх үзлэг хийж, Хорооны албан бичгээр холбогдох шаардлагыг хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллав.

Бусад асуудлаар тусгай зөвшөөрөлгүй зээлийн үйл ажиллагаа явуулсан, ломбард буюу барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа болон иргэд хоорондын зээлийн гэрээтэй холбоотой маргаанууд байв.

1.2.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан Хороонд нийт 12 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 5. ХЗХ-той холбоотой ирүүлсэн өргөдөл

Д/д	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл	2017/П
1	Зээлийн гэрээний маргаан	4
2	Хадгаламж, зээлийн хүүгийн маргаан	3
3	ХЗХ-ны үйлчилгээ	3
4	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	2

Өргөдөл, гомдлыг урьдчилан шийдвэрлэх явцад тухайн ХЗХ-ноос мэдээлэл болон холбогдох баримтуудыг авах, шаардлагатай тохиолдолд газар дээрх үзлэгийг хийж, хууль журмын дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажиллав.

Банк бус санхүүгийн байгууллага болон Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбогдуулан 2017 оны 2 дугаар улирлын байдлаар ирсэн өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн улиралтай харьцуулбал тооны хувьд ижил хэмжээнд байна.


2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 135 өргөдөл, гомдол ирснээс:

Хүснэгт 6. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн байдал	Тоо
Шийдвэрлэж, хариу өгсөн	128
<i>Үүнээс: хугацаанд нь шийдвэрлэсэн</i>	120
<i>Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн</i>	8
Шийдвэрлэх шатандаа байгаа	7
<i>Үүнээс: Хуулийн хугацаанд хянагдаж буй</i>	5
<i>Хугацааг нь сунган хянагдаж буй</i>	2

Дүрслэл 4. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоноогоор)



Өргөдөл, гомдлыг барагдуулах хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудад нийт 230 албан тоотыг хүргүүлэв. Үүнээс үүрэг, даалгавар өгөх, тайлбар, мэдээ авах, мэдэгдэл хүргүүлэх зэрэг хугацаатай 123 албан бичгийг хүргүүлж, тогтмол хяналт тавин биелэлтийг бүрэн хангуулжээ. Мөн өргөдөл гаргагчдад нийт 97 албан бичгээр Хорооны шийдвэрийн хариуг хүргүүлж ажиллав.

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч дундаж хугацааг богиносгох зорилготой ажиллаж байна.

Жич: Тайлант улирлын өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа 17 өдөр байсан ба хамгийн богино хугацаа 1 өдөр, хамгийн удаан нь 54 өдөрт шийдвэрлэгджээ.

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн хэрэглэгч зарим тохиолдолд санхүүгийн гэрээний нөхцлүүдтэй танилцаж, бүрэн гүйцэд таних боломжгүй байдаг тул тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага тухайн хэрэглэгчийг шийдвэр гаргахад нь шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд дор дурдсаныг зөвлөж байна. Үүнд:

НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

- Санхүүгийн үйл ажиллагаа нь хоёр талт гэрээний харилцаагаар зохицуулагддаг тул үйлчлүүлэгчид гэрээ болон түүний хавсралтад заасан нөхцлүүдтэй сайн танилцахгүйгээр санхүүгийн гэрээг байгуулахгүй, санхүүгийн байгууллагын ажилтнаас уг гэрээтэй дэлгэрэнгүй танилцах боломж олгохыг хүсэх;
- Санхүүгийн үйлчилгээний гэрээг баталгаажуулсны дараа уг гэрээнд заасан өөрийн хүлээх үүргийг хариуцлагатайгаар мөрдөж, биелүүлэх;
- Санхүүгийн гэрээ, аливаа төлбөр болон даатгалын нөхөн төлбөртэй холбоотой холбогдох баримтуудыг хадгалах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, санхүүгийн гэрээний маргаантай асуудал үүссэн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын холбогдох ажилтанд хандаж, шийдвэрлүүлэх, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хороонд хандан зөвлөгөө авах, шаардлагатай гэж үзвэл маягтын дагуу өргөдөл гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу тус Хороонд хандан урьдчилан шийдвэрлүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой маргаантай асуудлаар гарсан Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах;
- Хэрэв маргаантай асуудлаар гаргасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах.

Даатгуулагчдад

- Гэрээний нэгдсэн загварт баригдалгүйгээр өөрт тань тохирох тусгайлсан нөхцлийг санал болгож, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбогдох маргааныг Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хандан урьдчилан шийдвэрлүүлэх ба тус Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах.

Банк бус санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгчдэд

- Зээл олгогч бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн санал болгож буй гэрээний нөхцлүүдтэй харьцуулж, зээлийн дүн, хүү, алданги, зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай танилцсаны эцэст сонголт хийж, шийдвэрээ гаргах;
- Зээлийн даатгал нь албан журмын даатгалын төрөлд хамаарахгүй бөгөөд зөвхөн санхүүгийн хэрэглэгчийн зөвшөөрлийн үндсэн дээр байгуулахыг анхаарах;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар зээлдэгчийн зээлийн дансанд гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцох тул зээл, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээг бэлэн бус хэлбэрээр хийх;
- Зээлийн гэрээг дуусгавар болгосон тохиолдолд зээлдүүлэгчээс гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсан талаарх тодорхойлолт авч, Зээлийн мэдээллийн сан болон Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллагад шаардлагатай бүртгэлийг хийлгэх;
- Зээлийн гэрээнд санхүүгийн байгууллагын зүгээс санхүүгийн хэрэглэгчид мэдэгдэлгүйгээр дангаараа гэрээг цуцлах, гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах зэргээр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хөндсөн эсэхийг анхаарах;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол түүний хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр зохицуулсан байгааг анхаарах.

Хөрөнгө оруулагчдад /хувьцаа эзэмшигч/

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч эзэмшигч эсэх, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данс нээсэн эсэхээ www.schcd.mn цахим хуудсаар мэдээлэл авах, хэрэв данстай бол өөрийн харилцагч үнэт цаасны компани, эсхүл “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК³-д иргэний үнэмлэхтэй очин харилцагчийн дэлгэрэнгүй хуулгыг төлбөртэйгөөр гаргуулан авах;
- Хувьцааг нь эзэмшиж буй компанийн үйл хэрэгт /хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцох;
- Төвлөрсөн хадгаламжийн данс дахь үнэт цаас, бэлэн мөнгөний үлдэгдэлд тогтмол хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл тодорхой хугацаанд дансны гүйлгээг түр зогсоон царцаах;
- Өөрийн хэрэгцээ, шаардлагыг хангасан гэж үзсэн үнэт цаасны компанийг сонгон үйлчлүүлэх.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

³ Хаяг: Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Самбуугийн гудамж 16/1, Утас: 7012-0460